



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ЭРДЭНЭС АЛТ РЕСУРС ХХК 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Аудитын код: СНАГ-2025/062/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Улаанбаатар хот  
2025 он

Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,  
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг  
Утас: 261665 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)

Аудитын менежер: С.Нацагдорж  
Утас: 260512 Цахим хаяг: [natsagdorjs@audit.gov.mn](mailto:natsagdorjs@audit.gov.mn)

Ахлах аудитор: Б.Эрдэнэзул  
Утас: 260512 Цахим хаяг: [erdenezulb@audit.gov.mn](mailto:erdenezulb@audit.gov.mn)

Лайт энд Дилайт Аудит ХХК-ийн захирал: М.Нурболат  
Утас: 70007275 Цахим хаяг: [lightanddelightaudit@gmail.com](mailto:lightanddelightaudit@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.27 № 07/1242  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэс алт ресурс ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн нийт 8,521.8 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Хаягдлын сангийн даланг өндөрлөх, лагын насос суурилуулах 4,338.9 сая төгрөгийн ажлыг гүйцэтгүүлэхдээ худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй, хөрс хуулалт, олборлолт, ерөмдлөгийн ажил гүйцэтгэдэг туслан гүйцэтгэгч компанитай нэмэлт ажил байдлаар шууд гэрээ байгуулсан;
- Ажлын гүйцэтгэл гараагүй байхад туслан гүйцэтгэгч нарт нийт 2,880.0 сая төгрөгийн урьдчилгаа төлбөр олгосон зэрэг зөрчил нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.3, 31 дүгээр зүйлийн 31.1, 31.2, 44 дүгээр зүйлийн 44.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 5.1.4, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалтуудтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

## **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Компани нь тайлант хугацаанд 14.5 мянган тонн баяжмал үйлдвэрлэж, 18.1 мянган тонн баяжмал борлуулж, нийт 405,819.0 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллаж, борлуулалтын орлогын төлөвлөгөөг 40.7 хувиар давуулан биелүүлсэн байна.

Эрдэнэс Монгол ХХК, Эрдэнэс силвер ресурс ХХК-уудын 2020 онд байгуулсан Эрдэнэс-1 бондтой холбоотой 5 жилийн хугацаатай, жилийн 6 хувийн хүүтэй бондын санхүүжилтийн гэрээнээс тайлант хугацаанд бондын төлбөрт 80,000.0 сая төгрөгийг төлж, бондын өглөг 614,929.9 сая төгрөг, бондын хорогдуулаагүй хөнгөлөлт 235,043.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

## **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Салхитын мөнгө, алтны үндсэн ордын баруун болон төв эрлийн талбайн батлагдсан нөөцийг 2025 оны эхний хагаст олборлож дуусах төлөвлөгөөтэй байгаа ба дараа оныг дуустал баяжуулах үйлдвэрийг хүдрээр хангах тооцоотой байна.

Салхит мөнгө, алтны үндсэн ордын хаалтын менежментийн төлөвлөгөөнд 20.0 сая америк доллартой тэнцэх хэмжээний зардал тусгасан боловч компани 2023 он хүртэл уурхайн хаалт ба нөхөн сэргээлтийн нөөцийг 2,414.6 сая төгрөгөөр байгуулж, тайлант онд 3,000.0 сая төгрөгийг арилжааны банканд хадгалуулсан байгаа нь зардлыг бүрэн нөхөх боломжгүй байх эрсдэлтэй байна.

## **Бусад мэдээлэл**

Эрдэнэс алт ресурс ХХК нь 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдөр Ашигт малтмалын тухай хуулийн 26 дугаар зүйлийг үндэслэн Өмнөговь аймгийн Цогтцэций суманд орших Овоот хяр нэртэй 1,791.44 га ашиглалтын MV-022843 тоот тусгай зөвшөөрлийг авсан боловч техник эдийн засгийн үндэслэл болон тодотгол тайлан батлагдаагүй тул ашиглалт явуулах боломжгүй байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

## **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд Аудитын олон улсын стандартын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *Ц.Наранчимэг* Ц.НАРАНЧИМЭГ



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>		
1.1.1	Мөнгөн хөрөнгө	9,772,083,046.44	7,747,307,751.71
1.1.2	Дансны авлага	675,736,896.92	25,048,135,679.85
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	1,522,414,509.03	2,238,084,968.18
1.1.4	Бусад авлага	201,617,853.00	274,772,812.91
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	69,050,000,000.00	48,157,665,018.09
1.1.6	Бараа материал	66,940,995,550.93	45,037,339,027.46
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	575,399,911.29	1,077,793,208.15
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.9	Борлуулах бүлэг хөрөнгө	-	-
<b>1.1.20</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>148,738,247,767.61</b>	<b>129,581,098,466.35</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	74,921,105,020.59	64,689,488,296.38
1.2.2	Биет бус хөрөнгө	5,036,584,937.33	3,097,527,424.92
1.2.3	Биологийн хөрөнгө	-	-
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	22,461,475,182.75	26,812,831,123.81
1.1.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	-	-
1.1.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-	-
1.2.8	Хойшлогдсон бондын хөрөнгө	853,421,554,149.69	906,061,535,295.80
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>955,840,719,290.36</b>	<b>1,000,661,382,140.91</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,104,578,967,057.97</b>	<b>1,130,242,480,607.26</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	4,738,722,541.58	6,921,160,953.64
2.1.1.2	Цалингийн өглөг	-	-
2.1.1.3	Татварын өр	95,990,165,454.88	42,443,575,705.31
2.1.1.4	НДШ-ийн өглөг	-	-
2.1.1.5	Банкны богино хугацаат зээл	-	-
2.1.1.6	Хүүний өглөг	-	-
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	-	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	80,286,392,321.42	22,648,198,656.60
2.1.1.9	Нөөц (өр төлбөр)	-	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	1,926,180,248.85	693,839,129.30
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгөнд хамаарах өр	-	-
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>182,941,460,566.73</b>	<b>72,706,774,444.85</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл	-	-
2.1.2.2	Урт хугацаат нөөц (өр төлбөр)	2,414,595,900.00	2,414,595,900.00

2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	-	-
2.1.2.4	Бондын санхүүжилтийн өглөг	877,333,018,853.89	849,973,000,000.00
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>879,747,614,753.89</b>	<b>852,387,595,900.00</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>1,062,689,075,320.62</b>	<b>925,094,370,344.85</b>
<b>2.3</b>	<b>ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ</b>		
	Өмч		
2.3.1	Өмч: а) төрийн	101,000,000.00	101,000,000.00
2.3.2	б) хувийн	-	-
2.3.3	в) хувьцаат	-	-
2.3.4	Халаасны хувьцаа	-	-
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	-	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	-
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	28,703,725,699.86	28,703,725,699.86
2.3.9	Хуримтлагдсан ашиг, алдагдал	13,085,166,037.49	176,343,384,562.55
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>41,889,891,737.35</b>	<b>205,148,110,262.41</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,104,578,967,057.97</b>	<b>1,130,242,480,607.26</b>

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
<b>1</b>	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>150,023,801,652.76</b>	<b>423,463,911,351.68</b>
2	Борлуулалтын өртөг	47,496,407,925.36	172,801,575,644.50
<b>3</b>	<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>102,527,393,727.40</b>	<b>250,662,335,707.18</b>
4	Түрээсийн орлого	236,234,319.67	510,201,175.29
5	Хүүний орлого	132,353,799.45	14,640,667,557.49
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	54,369,005.67	150,538,806.40
9	Борлуулалт, маркетингийн зардал	7,126,225,063.01	32,464,425,856.44
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,789,375,139.77	14,189,015,670.18
11	Санхүүгийн зардал	545,843,818.70	-
12	Бусад зардал	1,075,207,498.26	1,777,136,750.88
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз гарз	(230,433,665.91)	321,101,301.05
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	-	-
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>92,183,265,666.54</b>	<b>217,854,266,269.91</b>
19	Орлогын татварын зардал	25,853,267,611.22	54,534,153,703.30
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>66,329,998,055.32</b>	<b>163,320,112,566.61</b>
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>66,329,998,055.32</b>	<b>163,320,112,566.61</b>
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
	Бусад олз (гарз)	-	-
<b>24</b>	<b>Орлогын нийт дүн</b>	<b>66,329,998,055.32</b>	<b>163,320,112,566.61</b>
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	<b>2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>100,000,000.00</b>	-	<b>(4,737,310,290.44)</b>	<b>(4,637,310,290.44)</b>
2	Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	1,328,822,732.58	<b>1,328,822,732.58</b>
3	<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>100,000,000.00</b>	-	<b>(3,408,487,557.86)</b>	<b>(3,308,487,557.86)</b>
4	Тайлангийн үеийн цэвэр ашиг	-	-	66,329,998,055.32	<b>66,329,998,055.32</b>
6	Өмчид гарсан өөрчлөлт	1,000,000.00	28,703,725,699.86	(49,836,344,459.97)	<b>(21,131,618,760.11)</b>
9	<b>2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>101,000,000.00</b>	<b>28,703,725,699.86</b>	<b>13,085,166,037.49</b>	<b>41,889,891,737.35</b>
10	Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(61,894,041.55)	<b>(61,894,041.55)</b>
11	<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>101,000,000.00</b>	<b>28,703,725,699.86</b>	<b>13,023,271,995.94</b>	<b>41,827,997,695.80</b>
12	Тайлангийн үеийн цэвэр ашиг	-	-	163,320,112,566.61	<b>163,320,112,566.61</b>
17	<b>2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>101,000,000.00</b>	<b>28,703,725,699.86</b>	<b>176,343,384,562.55</b>	<b>205,148,110,262.41</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>109,545,958,613.34</b>	<b>325,981,499,878.90</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	80,817,630,126.91	325,839,520,775.60
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	2,325,600.00	29,631,141.00
1.1.4	Буцаан авсан албан татвар	-	-
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	285,151,101.00	-
1.1.6	Бусад мөнгөн орлого	28,440,851,785.43	112,347,962.30
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>65,182,379,947.44</b>	<b>269,558,835,032.87</b>
1.2.1	Ажиллагчдад олгосон мөнгө	1,816,012,847.98	7,646,165,832.96
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	458,290,351.46	1,999,268,436.15
1.2.3	Түүхий эд материал худалдан авахад төлсөн мөнгө	15,995,626,174.97	88,556,008,805.56
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	2,285,172,468.67	9,334,519,579.72
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	3,816,693,323.14	15,038,921,711.30
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	1,691,683,527.42	0.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	37,665,722,028.25	136,270,272,422.12
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн мөнгө	12,223,458.00	290,604,926.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	1,440,955,767.55	10,423,073,319.06
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>44,363,578,665.90</b>	<b>56,422,664,846.03</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		-
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	-	<b>163,606,994,441.06</b>
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	151,052,000,000.00
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.5	Бусдад олгосон зээл, урьдчилгааны буцаан төлөлт	-	-
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	-	12,554,994,441.06
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>29,383,795,562.36</b>	<b>142,195,275,358.03</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	5,287,254,669.36	8,094,493,862.38
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	46,540,893.00	3,941,116,477.56
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	24,050,000,000.00	130,159,665,018.09
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(29,383,795,562.36)</b>	<b>21,411,719,083.03</b>

<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		-
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>169,031.45</b>	<b>175,582,951.36</b>
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.3	Төрөл бүрийн хандив	-	-
3.1.4	Бусад орлого	169,031.45	175,582,951.36
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>5,208,382,648.68</b>	<b>80,034,742,175.15</b>
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	5,065,677,793.20	80,000,000,000.00
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
3.2.4	Төлсөн ногдол ашиг	-	-
3.2.5	Бусад зарлага	142,704,855.48	34,742,175.15
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(5,208,213,617.23)</b>	<b>(79,859,159,223.79)</b>
<b>4</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>9,771,569,486.31</b>	<b>(2,024,775,294.73)</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>513,560.13</b>	<b>9,772,083,046.44</b>
<b>6</b>	<b>Мөнгөн, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>9,772,083,046.44</b>	<b>7,747,307,751.71</b>

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2023 он	2024 он			
		Гүйцэтгэл	Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>I. ОРЛОГЫН ҮЗҮҮЛЭЛТ</b>						
1.1	<b>Үндсэн борлуулалтын орлого</b>	<b>145,931,232.9</b>	<b>287,957,435.0</b>	<b>405,820,836.7</b>	<b>117,863,401.7</b>	<b>140.9</b>
1.1.1	Исэлдсэн хүдрийн орлого		-	1,789.3	1,789.3	-
1.1.2	Баяжмалын орлого	145,931,232.9	287,957,435.0	405,819,047.4	117,861,612.4	140.9
1.2	<b>Бусад орлого</b>	<b>4,515,525.9</b>	<b>6,984,031.0</b>	<b>32,944,482.2</b>	<b>25,960,451.2</b>	<b>471.7</b>
1.2.1	Хүүгийн орлого	132,353.8	-	14,640,667.6	14,640,667.6	-
1.2.2	Түрээсийн орлого	236,234.3	-	510,201.2	510,201.2	-
1.2.3	Даатгалын нөхөн олговрын орлого	2,584.0	-	32,923.5	32,923.5	-
1.2.4	Алданги торгуулийн орлого	51,104.3	-	112,441.0	112,441.0	-
1.2.5	Цахилгааны борлуулалт	1,220,440.5	6,984,031.0	7,328,211.7	344,180.7	104.9
1.2.6	Дизель түлш борлуулалт	2,835,687.4	-	10,283,389.1	10,283,389.1	-
1.2.7	Бараа материалын борлуулалт	37,121.5	-	36,648.1	36,648.1	-
	<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>150,446,758.8</b>	<b>294,941,466.0</b>	<b>438,765,318.9</b>	<b>143,823,852.9</b>	<b>148.8</b>
<b>II. ЗАРДЛЫН ҮЗҮҮЛЭЛТ</b>						
2.1	<b>Бүтээгдэхүүний өртөг</b>	<b>47,496,407.9</b>	<b>123,335,316.0</b>	<b>172,801,575.6</b>	<b>49,466,259.6</b>	<b>140.1</b>
2.1.1	Хүдрийн өртөг		-	103.8	103.8	-
2.1.2	Баяжмалын өртөг	43,443,373.9	122,835,316.0	155,361,512.0	32,526,196.0	126.5
2.1.3	Металлын өртөг	-	-	-	-	-
	Цахилгааны борлуулалт	1,220,440.5	-	7,328,211.7	7,328,211.7	-
	Дизель түлш борлуулалт	2,796,154.8	-	10,080,240.2	10,080,240.2	-
	Бараа материалын борлуулалт	36,438.8	-	31,508.0	31,508.0	-
2.1.4	Эрсдэлийн зардал		500,000.0	-	(500,000.0)	-
2.5	<b>Ерөнхий ба борлуулалт удирдлагын зардал</b>	<b>10,484,774.7</b>	<b>43,516,386.0</b>	<b>48,430,578.3</b>	<b>4,914,192.3</b>	<b>111.3</b>
3	<b>Үйл ажиллагааны бус орлого, зарлага</b>	<b>(282,310.5)</b>	<b>-</b>	<b>321,101.3</b>	<b>321,101.3</b>	<b>-</b>
	Найдваргүй авлагын нөөц	(51,876.8)	-		-	-
	Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз (гарз)	(230,433.7)	-	321,101.3	321,101.3	-
<b>III. АШГИЙН ҮЗҮҮЛЭЛТ</b>						
4.1	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг</b>	<b>92,183,265.7</b>	<b>128,089,764.0</b>	<b>217,854,266.3</b>	<b>89,764,502.3</b>	<b>170.1</b>
	ААНОАТ	25,853,267.6	31,122,441.0	54,534,153.7	23,411,712.7	175.2
4.2	<b>Татварын дараах цэвэр ашиг</b>	<b>66,329,998.1</b>	<b>96,967,323.0</b>	<b>163,320,112.6</b>	<b>66,352,789.6</b>	<b>168.4</b>
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>						
5	<b>Хөрөнгө оруулалт</b>	<b>14,161,988.5</b>	<b>26,430,619.8</b>	<b>8,405,961.5</b>	<b>18,024,658.3</b>	<b>31.8</b>

### 3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 8,675.8 сая төгрөгийн 4 алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 8,675.8 сая төгрөгийн 4 алдааг залруулав.

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Худалдан авагчтай байгуулсан гэрээний дагуу урьдчилгаа нэхэмжлэхийн дүнгээр орлого хүлээн зөвшөөрч, баяжмалын эцсийн шинжилгээний хариуг үндэслэн нэхэмжлэхийн дүнгээр орлогын эцсийн дүнг тодорхойлдог. Энэхүү хоёр нэхэмжлэхийн дүнгийн зөрүүгээр тохируулга хийдэг бөгөөд тайлант хугацаанд 8,570.2 сая төгрөгийн үнийн тохируулга бүртгээгүйгээс орлого /авлага/ дутуу илэрхийлсэн.	1	8,570,206.5	1	8,570,206.5	-	-	1	8,570,206.5	-	-	-	-
Микс трейд ХХК-ын өглөгийн тооцооноос гэрээний дагуу суутгасан байсан хүү алдангийн орлогыг /өглөгийг хаагаагүй/ дутуу тайлагнасан.	1	5,236.0	-	-	1	5,236.0	1	5,236.0	-	-	-	-
Худалдаа хөгжлийн банкин дахь харилцах дансны үлдэгдлийг илүү илэрхийлсэн байна.	1	5.0	1	5.0	-	-	1	5.0	-	-	-	-
Борлуулалтын залруулгын нөлөөгөөр нэмэгдсэн гадаад валютаарх авлагын үлдэгдэлд ногдох ханшийн зөрүүг нөхөж тооцоогүй байна.	1	100,337.9	1	100,337.9	-	-	1	100,337.9	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>8,675,785.4</b>	<b>3</b>	<b>8,670,549.4</b>	<b>1</b>	<b>5,236.0</b>	<b>4</b>	<b>8,675,785.4</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

3.2 Аудитаар нийт 8,521.8 сая төгрөгийн 5 зөрчил<sup>2</sup> илэрснээс, 32.9 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 4,360.1 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, өмнөх оны аудитаар хүргүүлсэн худалдан авалттай холбоотой албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүйтэй холбоотой 1,248.8 мянган төгрөгийн зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлж, 2,880.0 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Ажлын гүйцэтгэл гараагүй байхад туслан гүйцэтгэгч нарт нийт 2,880.0 сая төгрөгийн урьдчилгаа төлбөр олгосон.	1	2,880,000.0	-	-	-	-	1	2,880,000.0	-	-	-	-
Худалдан авалтыг түүвэрлэн шалгахад худалдан авалтын төлөвлөгөөнд тусгаагүй 15 удаагийн 1,153.7 сая төгрөгийн, ерөнхий гэрээгээр худалдан авахаар төлөвлөсөн боловч шууд худалдан авалт хийсэн 2 удаагийн нийт 72.8 сая төгрөгийн, багц болгож төлөвлөх боломжтой байсан 22.2 сая төгрөгийн худалдан авалт нь худалдан авах ажиллагааны журам зөрчсөн, өмнөх оны аудитаар хүргүүлсэн худалдан авалттай холбоотой хүргүүлсэн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.	1	1,248,760.7	-	-	-	-	-	-	1	1,248,760.7	-	-
Хаягдлын сангийн даланг өндөрлөх, лагын насос	1	4,338,949.0	-	-	1	4,338,949.0	-	-	-	-	-	-

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

суурилуулах 4,338.9 сая төгрөгийн ажлыг гүйцэтгүүлдээ худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй, 2021 онд Сидар ХХК-тай байгуулсан "Хөрс хуулалт, олборлолт, өрөмдлөгийн ажил гүйцэтгэх гэрээ"-ний нэмэлт ажил байдлаар шууд гэрээ байгуулсан байна.												
Компанийн удирдлагууд хот дотор суудлын автомашин ашиглаж 32.9 сая төгрөгийг шатахууны зардал гаргасан.	1	32,918.4	1	32,918.4	-	-						
Байгууллагын хөрөнгөөр 21.2 сая төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдаж авсан.	1	21,192.0	-	-	1	21,192.0						
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>8,521,820.1</b>	<b>1</b>	<b>32,918.4</b>	<b>2</b>	<b>4,360,141.0</b>	<b>1</b>	<b>2,880,000.0</b>	<b>1</b>	<b>1,248,760.7</b>	<b>-</b>	<b>-</b>

3.3 АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар 1 зөрчил илэрсэнд зөвлөмж өглөө.

#### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Эрдэнэс алт ресурс ХХК зорилтот түвшин, гүйцэтгэл, санхүүгийн тайлан, дараа жилийн зорилтот түвшин, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан зэрэг нийт 5 мэдээг шилэн дансны цахим системд хугацаа хоцроож мэдээлсэн байна.	1	-	-	-	-	-	1	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>